



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/07

Булган сум

“Эрүүл Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV дүгээр хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Эрүүл Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Б.Батбаяр (Аймгийн Засаг даргын Эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх)
	М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)
	П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
	Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)
	Б.Урангаваа (Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
	Д.Батдэлгэр (Эрүүл мэндийн газрын Удирдлага мэдээллийн хэлтсийн дарга)
	Д.Зоригтбаатар (Нэгдсэн эмнэлгийн дарга)
	Д.Отгонсүрэн (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2. “Эрүүл Булган” хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж, 2025 оны I улиралд батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6375010003